



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/808

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардчилсан хувьсгалын 30 жилийн ойг аймагт тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах зардалд 1500000 төгрөг, бөхийн барилдааны зардалд 2000000 төгрөгийг баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 3 500 000 төгрөг /Гурван сая таван зуун мянган /-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга / Д.Энхболд /-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал /-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ